БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт маягтын дагуу гаргав.

НЭГ. Товч танилцуулга[1]

Боловсролын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/129 дүгээр тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулагдсан.

Боловсролын салбарын хэмжээнд нийт Боловсролын яам болон харьяа байгууллагын дэргэдэх 7 ёс зүйн дэд хороо, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дэргэдэх 22, төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын 1003, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 698, насан туршийн суралцахуйн төвийн 28, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 40, дээд боловсролын сургалтын байгууллагын 11, нийт 1809 ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж байна.

Судалгаагаар дээрх ёс зүйн дэд хороод нь нийт 7789 гишүүнтэй байгаа ба байгууллагын ажилтан, албан хаагчдын тооноос хамааран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4-т заасны дагуу харилцан адилгүй байна.

Статистик тоогоор Монгол Улсын хэмжээнд төрийн өмчийн цэцэрлэг буюу сургуулийн өмнөх 1019 байгууллагад 32096 ажилтан, ерөнхий боловсролын 717 байгууллагад 55092 ажилтан, насан туршийн суралцахуйн 30 төвд 406 ажилтан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 42 байгууллагад (мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж) 3114 ажилтан, дээд боловсролын 18 байгууллагад 6428 багш, ажилтан ажиллаж байгаагаас гадна Боловсролын яаманд 97 ажилтан, албан хаагч, харьяа 7 байгууллагад 341 ажилтан албан хаагч, аймаг, нийслэлийн Боловсролын газар 22 байгууллагад 566 албан хаагч ажиллаж байна.

Дээрх статистик тоогоор төрийн захиргааны болон боловсролын сургалтын **1856** байгууллага байгаагаас зарим салбар сургууль нь дээд сургуулийнхаа Ёс зүйн дэд хороонд хамаарч, харин шинээр байгуулагдан үйл ажиллагаа нь эхлээгүй, бүтэц орон тоо нь батлагдаагүй цэцэрлэг, сургуулиуд нь ёс зүйн дэд хороо байгуулаагүй байна.

Яам, харьяа байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Боловсролын газар, хэлтсээс бусад төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллага нийт 1826 байгаа ба түүнд нийт 97137 ажилтан, албан хаагч ажиллаж байна.

Боловсролын яам, Боловсролын Ерөнхий газар, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь байгууллагынхаа албан хаагчдын болон эрх бүхий албан тушаалтны томилж байгаа боловсролын сургалтын байгууллагын удирдлагын ёс зүйн зөрчлийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Тухайлбал:

- Боловсролын яам нь өөрийн байгууллага дахь 97 албан хаагчаас гадна харьяа 7 байгууллага, аймаг, нийслэлийн 22 Боловсролын газрын даргын ёс зүйн асуудлыг,
- Боловсролын ерөнхий газар нь өөрийн байгууллагын 123 албан хаагчаас гадна төрийн өмчийн 42 мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирлын, 30 насан туршийн суралцахуйн төвийн захирлын ёс зүйн асуудлыг,
- Нийслэлийн Боловсролын газар нь 69 албан хаагчаас гадна 8 дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, албан хаагчдын /4-12 албан хаагчдын/, мөн

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

нийслэлийн төрийн өмчийн 317 цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын 167 сургуулийн захирлын ёс зүйн асуудлыг,

- Аймгийн Боловсролын газар нь өөрийн байгууллагын 30-40 албан хаагчийн болон аймаг, сумын цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлын ёс зүйн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд боловсролын салбарын Ёс зүйн дэд хороод нь 2025 онд давхардсан тоогоор нийт 3307 сургалт, 326 аян, 950 удаагийн нөлөөллийн арга хэмжээг 110672 ажилтан, албан хаагчийг хамруулан зохион байгууллаа. Мөн боловсролын сургалтын байгууллагууд нь суралцагч, эцэг эхчүүдэд ёс зүйн тухай ойлголт, ёс зүйтэй иргэн байх зэрэг хөгжил төлөвшлийн аян, сургалтуудыг өөрийн байгууллага дээрээ зохион байгуулан ажилладаг.

Зохион байгуулсан сургалтаас дурдвал:

1.Ёс зүйн хороотой хамтран Боловсролын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр харьяа байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газрын удирдах албан тушаалтан болон Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг хамруулсан “Ёс суртахууны төлөвшил”, “Боловсролын үнэт зүйлсийн суурь багана” сэдэвт сургалтыг доктор.профессор /ёс зүйн хорооны гишүүн Ш.Батсүх, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, журмын талаар Ёс зүйн хорооны соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяахүү нараар мэдээлэл хийлгэн, боловсролын салбарын онцлог, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, гомдол мэдээллийн харьяаллыг хэрхэн шийдвэрлэх талаар санал бодлоо солилцсон.

2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Боловсролын яам, түүний дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь жил бүрийн 10 дугаар сарын гурав дахь долоо хоног “Дэлхийн ёс зүйн өдөр”-ийг угтан 2025 оны 10 сард Дундговь аймгийн Боловсролын газар, тус аймгийн боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нар болон ёс зүйн хорооны дарга, гишүүдэд тухайн орон нутагт сургалт зохион байгуулж, гарын авлага бэлтгэн тараасан. Сургалтад тус аймгийн Боловсролын газрын ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, политехник коллежийн захирал, эрхлэгч, ёс зүйн дэд хорооны гишүүд зэрэг нийт 150 төрийн албан хаагч танхим болон цахимаар хамрагдсан ба ёс зүйн тухай ойлголт, харьяалал, гомдол мэдээллийг шийдвэрлэх, дүгнэлтийг хэрхэн гаргах талаар мэдээлэл хийн, оролцогчдыг кейс судалгаанд тулгуурлан багаар ажиллуулж, санал солилцон хэлэлцүүлэг зохион байгуулсан нь нилээд үр дүнтэй ажил болсон.

Мөн Боловсролын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүд нь Дундговь аймгийн Боловсролын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай танилцаж, ёс зүйн асуудлаар гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, байгууллагын ажилтнууддаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

3.Боловсролын салбарын Ёс зүйн дэд хороод нь багш, ажилчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн хуульч, өмгөөлөгч нараар сургалт зохион байгуулах, Хувь хүний хөгжлийн институттай хамтран "Ажлын байран дахь хил хязгаар", "Удирдлагын багт", “Удирдах ур чадвар", "Зан чанарыг танин мэдэхүй" сэдэвт сургалт, "Аз

[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

жаргалтай ажлын байр", "Багш, ажилтны зөв оновчтой идэвхжүүлэх арга зүй", "Байгууллагын уур амьсгалыг сайжруулах нь", "Байгууллагын соёлыг хэрхэн бүрдүүлэх вэ?", "Тета долгионоор стрессийг удирдах нь", “Ёс зүйн манлайлал ба харилцаа хандлага”, "Хүндэлье энэрье", "Хүндэлье", "Тусалж дэмжье", "Талархъя", “Ууч сэтгэлээр хандъя”, Монгол Улсын зөвлөх багш н.Батаа “Өнөө цагийн боловсролын ажилтны дүр төрх харилцаа, ёс зүй” сэдэвт, УТИС-н Хууль зүйн багш, хууль зүйн докторант Ц.Өлзийтогтох “Ёс зүй миний амьдралд” сургалт, НТБ-н багш Х.Гантуул “Хамт олны харилцаа” сургалт, “Хүүхэд хүмүүжүүлэх эрэг арга” сургалт, НТСТ-багш Я.Дүүрэнгэрэл “Хувь хүний харилцаа”, "Ёс зүйн дүрэм ба хууль тогтоомж", "Олон нийтийн цахим сүлжээ ба багшийн ёс зүй", “Эерэг харилцааг өөрөөсөө”, “Бие биенээ хүндэлж хайрлая”, “Зөвөөр үлгэрлэе” зэрэг сэдвүүдээр сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 37189 багш, ажилтан хамрагдсан.

Боловсролын сургалтын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь багш, ажилтан, удирдах ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, иргэн, хуулийн этгээд нь хууль тогтоомжийн хүрээнд холбогдох эрх, үүргийнхээ дагуу албан үйл ажиллагаанд эерэг харилцааг бий болгох, хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдаж өөрийгөө хөгжүүлэх, хэн нэгэнд гомдол бухимдал үүсгэхээс урьдчилан сэргийлж, зөрчил дутагдал гаргалгүй ажиллах, аливаа үүссэн асуудлыг шийдвэрлэхдээ нөхцөл шалтгаан, үндэслэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг тооцоолох, хууль эрх зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар холбогдох зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаж байна.

Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан 2025-2028 онд хэрэгжүүлэх “Багшийн хөгжил” гурван жилийн хөтөлбөрт “Багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, багш ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах” арга хэмжээг тусган, түүний хүрээнд ахмад багш нарын хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, "Багшдаа захидал бичээрэй" захидлын уралдаан, залуу багш нарын ур чадвар, арга зүйн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх "Бидэнд туршлага байна" туршлага солилцох үйл ажиллагаа, аян зэргийг зохион байгууллаа.

Мөн олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан багш мэргэжлийн онцлог, давуу талыг сурталчлах, багшийн ёс зүй, багшлахуйн сайн туршлага, арга зүйг түгээх зорилго бүхий "Багшийн цаг", “Арга зүйчийн цаг” зэрэг зорилтот подкаст, нэвтрүүлэг, хөрөг, намтар зэргийг бүтээх, түгээн сурталчлах ажлуудыг төлөвлөн, үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ба албан хаагчдын ёс зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөмж, чиглэл өгч ажиллав.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 12 дугаар зүйлийн 12.1.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 заалтуудыг үндэслэн байгууллага бүрийн дэргэд Ёс зүйн дэд хороо байгуулан, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах хүрээнд өөр өөрийн боловсруулсан төлөвлөгөөний дагуу дэд хорооны үйл ажиллагааг зохион байгуулан хэвшүүлж, тодорхой үр дүнд хүрч байна.

Боловсролын сургалтын байгууллагын албан тушаалтнууд нь шударга, ил тод, хариуцлагатай төрийн алба, байгууллагын соёлыг төлөвшүүлэн, ёс зүйн хэм хэмжээг сахих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ёс зүйн манлайллыг үзүүлэхийг эрхэмлэн, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Удирдах ажилтны манлайллыг ханган ажиллах, ёс зүйгээр үлгэрлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч нарт “Ёс зүйгээрээ үлгэрлэе” аян, “Өөрөөсөө эхэлье” сургалт хэлэлцүүлэг, “Багш, удирдах ажилтны зөөлөн ур чадвараар ёс

зүйн зөрчлийг бууруулах нь" асуудал дэвшүүлсэн хэлэлцүүлэг, сургалт мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулж, багш, удирдах ажилтны харилцааны зөөлөн ур чадвар буюу Эгэх харилцаа, Сонсох ур чадвар, Илтгэх ур чадвар, Үгэн бус харилцаа, Мультмедиа харилцааны чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нөлөөллийн олон талт арга хэмжээг Ёс зүйн дэд хороод дор бүрнээ зохион байгуулсан.

Удирдах ажилтны ёс зүйн манлайллыг дээшлүүлэх арга замыг сайжруулах чиглэлээр хамт олны дунд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар салбарын хэмжээнд ёс зүйн зөрчил өмнөх оны мөн үеэс 8.6%-иар буурсан үр дүнтэй байна.

Аймаг, нийслэлийн Боловсролын газрууд нь ил тод, шударга удирдлагын зарчмыг баримтлан, авлига, ашиг сонирхол, шан харамж, хээл хахууль авах, өгөхөөс татгалзах, ялгаварлан гадуурхахгүй байх, сурлагын амжилтыг бодитой үнэлэх, хууль бус төлбөр хураамж авахгүй байх талаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагатай байгуулж буй гэрээнд тусган, зөвлөмж, чиглэл өглөө. Мөн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг олон нийтийн өмнө тогтмол тайлагнаж, санал, сэтгэл ханамжийн судалгааны дүнг хамт олон, эцэг эхэд танилцуулж ажиллах талаар захирал, эрхлэгч нартай байгуулж буй гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг тооцож ажилласан.

Албан хаагчдыг ажилд томилох, албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох үйл ажиллагаанд ёс зүйн зарчим, шударга байдлыг чанд мөрдөж байна.

Тайлант хугацаанд боловсролын салбарын удирдах ажилтантай холбоотой нийт 47 гомдол мэдээлэл хүлээн авч, хянан шийдвэрлэж, ёс зүйн зөрчил гаргасан 9 албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцон, зөвлөмж чиглэл өгсөн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Боловсролын яам, харьяа байгууллага, аймаг, нийслэлийн Боловсролын газар, боловсролын сургалтын байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороод нь байгууллагынхаа болон салбарын ажилтнуудын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гарсан зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан ил тод, хариуцлагатай, хараат бус байдлыг ханган ажилласан.

Боловсролын салбарын Ёс зүйн дэд хороод нь 2025 онд нийт 519 гомдол мэдээлэл хүлээн авч, хэлэлцэж шийдвэрлэн, 330 дүгнэлт гаргасан. Дүгнэлтийн 145 нь ёс зүйн зөрчил гаргасан, 183 нь ёс зүйн зөрчил гаргаагүй талаар дүгнэлт байгаа ба 2 нь хүчингүй болгосон дүгнэлт байна. 2025 онд Боловсролын яамны албан хаагчидтай холбогдох өргөдөл гомдол харьцангуй бага ирж, байгууллагын албан хаагчид ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байхад анхаарч байна.

Боловсролын яамнаас 2025 оныг "Байгууллагын соёл, багшийн ёс зүй" зорилтот жил болгон зарласантай холбогдуулан боловсролын салбарын албан хаагчдад чиглэсэн аливаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйт манлайлал, соёлыг түгээх, соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны онцлог болон багш хүний ёс зүй, багш мэргэжлийн үнэ цэнийг эцэг эх, иргэд олон нийтэд сурталчлан таниулах, сайн туршлага, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх ажлуудыг боловсролын салбарын байгууллагууд дор бүрнээ зохион байгуулж ажиллалаа.

2025 онд давхардсан тоогоор нийт 3307 сургалт, 326 аян, 950 удаагийн нөлөөллийн олон талт үйл ажиллагааг байгууллага бүр Ёс зүйн дэд хороогоороо дамжуулан зохион байгуулснаар салбарын төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг сайжирч, хувь хүний сахилга хариуцлага дээшлэн, хуулийг сахин мөрдөх, ёс зүйн хэм хэмжээг баримтлах, сургалтын байгууллагын гадаад, дотоод орчинд болзошгүй эрсдэлт нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зэрэг олон эерэг үр дүнд хүрсэн.

Мөн нэгж байгууллагуудын Ёс зүйн дэд хорооны гишүүдийн вайбэр, фэйсбүүк групп нээн, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад

холбогдох хууль, дүрэм журам, үндэсний хөтөлбөрийн талаарх болон цаг үеийн мэдээ мэдээлэл, зөвлөмж чиглэлийг тухай бүр хүргэж, идэвхижүүлэн, харилцан туршлага солилцон, мэдээ мэдээллээ хуваалцах байдлаар ашиглаж байна.

Ёс зүйн хороо болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хууль зүйн хэлтэст Боловсролын яам болон харьяа газар, төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны орон тоо, шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоон мэдээг нэгтгэн гаргаж, хүргүүлсэн.

Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд ёс зүйн дэд хорооны гишүүдийн бүртгэлийг хөтөлж, төлөвлөгөө, өргөдөл гомдлын мэдээллийг тухай бүр оруулж хэвшлээ.

Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгуудын болон нийслэлийн боловсролын сургалтын байгууллагууд эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Яам, боловсролын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь доод шатны буюу сургууль, цэцэрлэгийн ёс зүйн дэд хороодод өргөдөл гомдол гаргагч болон холбогдогч нарт албан ажлын чиг үүрэгт холбогдох дээд албан тушаалтны өгсөн зөвлөмж, чиглэл, мэдээлэл, тайлбарыг тодорхой авч хамтран ажилладаг байх, багш, ажилтан, удирдах ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, иргэн, хуулийн этгээд нь хууль тогтоомжийн хүрээнд холбогдох эрх, үүргийнхээ дагуу албан үйл ажиллагаанд эерэг харилцааг бий болгох, хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдаж өөрийгөө хөгжүүлэх, хэн нэгэнд гомдол бухимдал үүсгэхээс урьдчилан сэргийлж, зөрчил дутагдал гаргахгүй байхад анхаарах, аливаа үүссэн асуудлыг шийдвэрлэхдээ нөхцөл шалтгаан, үндэслэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг тооцоолох, хууль эрх зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмжийг тохиромжтой хэлбэрээр нь /утсаар, биеэр, цахимаар, цаасаар/ тухай бүр өгч ажиллаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	***Бэрхшээл:***
- Нэгж байгууллага тус бүрт Ёс зүйн дэд хороод шинэчлэгдэн байгуулагдсан. - Байгууллагуудын нийт багш, ажилчид ёс зүйн үндсэн ойлголт, мэргэжлийн ёс зүйн зарчим, ёс зүйн алдаа, хариуцлагын талаарх мэдлэг сайжирч, харилцан хэлэлцүүлэг, ярилцлагаар дамжуулан ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг нийтээрээ ойлгож, өдөр тутмын ажилдаа хэвшүүлэх хүсэл эрмэлзэл, багийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, ажилдаа болон амьдралдаа хэрэгжүүлэх бүтээлч санаачилга, хандлага нэмэгдсэн. - Багш, ажилчид, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ёс зүйтэй холбоотой асуудлыг ёс зүйн дэд хороонд хандан шийдвэрлүүлдэг болсон. - Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем хөтлөлт, ашиглалтын хувь нэмэгдсэн. - Ёс зүйн дэд хороодын ажиллах журам, бусад холбогдох хууль эрх зүйн талаар соён гэгээрүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж, зөвлөгөө зөвлөмж	- Боловсролын яам, Боловсролын Ерөнхий газар, аймаг, нийслэлийн Боловсролын газрууд нь байгууллагын албан хаагчдын болон тухайн байгууллагаас томилогдож байгаа боловсролын сургалтын байгууллагын удирдлагын ёс зүйн зөрчлийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж байгаа нь ёс зүйн дэд хорооны гишүүдийн ажлын ачааллыг улам нэмэгдүүлж байна. - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн 13.4.1 дэх заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 3.7-д заасан урамшуулал Ёс зүйн дэд хорооны гишүүдэд бүрэн олгогддоггүй. - Ач холбогдол багатай, ажиллагаа ихтэй тоон мэдээлэл, мэдээ тайлангийн маягтууд батлагдан, салбарын хэмжээний мэдээллийг богино хугацаанд нэгтгэн хүргүүлж байгаа нь хүндрэл чирэгдэл үүсгэдэг. - Ёс зүйн дэд хорооны гишүүд нь өөрийн үндсэн албан тушаалын чиг үүрэг дээр нэмэлтээр ёс дэд хорооны гишүүний үүрэг хариуцлагыг хүлээн өргөдөл гомдлыг

чиглэл өгч ажилласнаар нэгж байгууллагуудын ёс зүйн дэд хороод улам чадваржин үүссэн асуудал, өргөдөл гомдлыг холбогдох хууль, журмын хүрээнд нэгж дээрээ шийдвэрлэдэг болсон нь салбарын ёс зүйн дэд хороонд гаргах өргөдөл гомдол буурсан. - Сурагчдын дунд хувь хүний ёс зүйн тухай ойлголт, ёс зүйн талаар мэдээлэл өгч, аян, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулснаар сурагчид хоорондын харилцаа хандлага бусдад эерэгээр хандах байдал, хувийн зохион байгуулалт нь сайжирч байна.	судалж, шийдвэрлэн ажиллахад их цаг хугацаа зарцуулагдан ажлын ачаалал нэмэгдэж, хууль, шүүхийн байгууллагад баримт бичиг болон тайлбар тодруулга өгөх, ялангуяа зарим сургууль, цэцэрлэг дээр гаргаж буй шийдвэрийн улмаас дарамт шахалт ирдэг тул байгууллага дотроо хэл аманд өртөх, сэтгэл санааны дарамт шахалтад орох зэргээс болж ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллахаас татгалзах тохиолдол гарч байна. - Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт хэт олон арга хэмжээ төлөвлөсөн, хэрэгжилтийг зохион байгуулахад төсөв санхүүгийн хүндрэл бэрхшээл гардаг. - Зарим сургууль, цэцэрлэгүүдийн дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь ажилтнуудын хооронд үүссэн харилцааны зөрчил, сэтгэл зүйн байдлаас үүдсэн маргаан, хувийн шинжтэй гомдлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг ба Ёс зүйн дэд хорооны гишүүдийг үл ойлгох хандлага гарч байна. - Эцэг эхийн харилцаа хандлага, ойлголтоос шалтгаалсан хүндрэлүүд гардаг. - Эцэг, эхтэй холбоотой хууль ёсны хариуцлагын ёс зүйн дүрэм журам сул байдлаас өөрийн үзэл бодлоо тулгах зарим тохиолдолд багш, ажилтны нэр хүндэд халдах, гүтгэх зэрэг эрсдлүүд үүсдэг. - Ёс зүйн чиглэлээр дагнасан сургалтын материал, гарын авлага хангалтгүй.

Санал:

- Ёс зүйн дэд хорооны гишүүд нь ёс зүйтэй төрийн албан хаагчийг төлөвшүүлэхэд өндөр үүрэг хариуцлагатай ажиллаж, ажлын ачаалал их байдаг тул урам зориг, нэмэлт баталгаа болсон урамшууллын асуудлыг шийдвэрлэх, цаашдаа сар бүр тогтмол хувь тогтоон олгодог болгох, мөн урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлын санхүүжилтийг тухайн байгууллагын жил бүрийн төсөвт суулгах шаардлагатай байна.
- Салбарын байгууллагын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг сайжруулах ажлын нөхцлийг тооцож, ажиллах нөхцөл боломжоор хангаж дэмжлэг үзүүлэх, сургалт нөлөөллийн ажлын ур чадварыг дээшлүүлэх менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай.
- Боловсролын салбарын төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь байгууллагынхаа албан хаагчдаас гадна салбарын удирдах ажилтны ёс зүйн асуудлыг шийдэж байгаа нь хүндрэлтэй байгаа тул боловсролын салбарын Ёс зүйн дэд хороодын харьяалал, зохицуулалтыг тодорхой болгох.
- Цаашид ёс зүйн сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, бодит кейсэд тулгуурлан хэлэлцүүлэг, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, багш, ажилтны мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх.
- Иргэдэд, ялангуяа эцэг эх, асран хамгаалагч нарт ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлагын талаар ойлголт мэдээлэл, контент, зөвлөгөө зөвлөмж гарган хүргэх.

- Орон нутгийн болон салбар дундын төрийн албан хаагчдын ёс зүйн дэд хороодын хамтын ажиллагааг сайжруулах.
- Цахим бүртгэлийн сангийн бүртгэл мэдээллийг төрийн албан хаагчийн бүртгэл мэдээлэлтэй уялдуулан холбох.
- Ёс зүйн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, үр дүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
- Албан хаагчдад зориулсан ёс зүйн гарын авлага боловсруулж, түгээн тараах.

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Боловсролын яамны
Төрийн нарийн бичгийн дарга ..... Х.Батжаргал

Ёс зүйн дэд хорооны дарга
Салбарын хяналт, шинжилгээ-үнэлгээ,
Дотоод аудитын газрын дарга ..... Л.Төгсбаяр

Ёс зүйн дэд хорооны гишүүн
Салбарын хяналт хариуцсан
ахлах мэргэжилтэн ..... А.Мөнх-Эрдэнэ

Огноо: ..... оны ..... сарын .....

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	*2*	*3*		*4*	*5*	*6*
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	0.93	9.3
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0.6	6
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос дээшгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.46	4.6
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.47	4.7
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.36	3.6
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.44	4.4
Хэсгийн оноо				**4**	**3.26**	**32.6**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0.93	9.3
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0.89	8.9
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.26	2.6
Хэсгийн оноо				**3**	**2.08**	**20.8**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	0.97	9.7
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0.81	8.1
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0.87	8.7
Хэсгийн оноо				**3**	**2.65**	**26.5**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**7.99**	**79.9**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	БСҮХ	БМИҮЗ	БҮТ	Архангай аймаг	Баян-Өлгий аймаг	Баян-хонгор аймаг	Булган аймаг	Говь-Алтай аймаг	Говь-сүмбэр аймаг	Дархан-Уул аймаг	Дорно-говь аймаг	Дорнод аймаг	Дунд-говь аймаг	Завхан аймаг	Орхон аймаг	Өвөр-хангай аймаг	Өмнө-говь аймаг	Сүх-баатар аймаг	Сэлэнгэ аймаг	Төв аймаг	Увс аймаг	Ховд аймаг	Хөвсгөл аймаг	Хэнтий аймаг	нийслэл	Оноо[1]	Хувийн жин[2]
1	*2*	*3*		*4*																									*5*	*6*
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	0.2	1	1	1	1	1	0.9	1	1	0.8	0.93	1	0.9	1	1	1	1	0.98	1	1	1	1	0.6	1	0.94	0.93	9.3
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	0	0	0	0.67	0	0.9	0	0.5	0.8	0.55	1	0.8	0	1	1	1	0.81	0	1	1	1	0.5	0.8	0.62	0.6	6
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	0,5	0	0.5	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.49	0.5	0.4	0,5	0.5	0.5	0.5	0.49	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.4	0.46	0.46	4.6
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	0,5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.3	0.5	0.5	0.50	0.5	0.4	0,5	0.5	0.5	0.5	0.48	0.5	0.5	0.5	0.5	0.3	0.4	0.47	0.47	4.7
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.2	0,5	0	0.5	0.44	0.5	0.4	0.2	0	0.5	0.61	0.5	0.3	0,5	0.5	0.5	0.5	0.06	0.5	0.5	0.5	0	0.3	0.5	0.32	0.36	3.6
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0	0,5	0.5	0.5	0.48	0.5	0.4	0.5	0.5	0.5	0.55	0.5	0.3	0,5	0.5	0.5	0.5	0.25	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.3	0.35	0.44	4.4
Хэсгийн оноо				**4**	**2.4**	**3**	**2**	**3**	**3.49**	**3**	**3.6**	**2.5**	**3**	**3.6**	**3.63**	**4**	**3.1**	**3**	**4**	**4**	**4**	**3.07**	**3**	**4**	**4**	**3.5**	**2.7**	**3.4**	**3.15**	**3.26**	**32.6**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	1	1	1	1	1	1	0.8	1	1	0.82	1	0.9	1	1	1	1	0.97	1	1	1	0	0.8	1	0.94	0.93	9.3
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	1	1	1	0.84	1	0.9	0	1	1	0.64	1	0.7	1	1	1	1	0.77	1	1	1	1	0.9	0.8	0.68	0.89	8.9
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.8	0	0	1	0.41	0	0.8	0.6	0	0	0.27	0	0.1	0	0	0	0	0.34	0.5	0	0	0	0.2	1	0.48	0.26	2.6
Хэсгийн оноо				**3**	**2.8**	**2**	**2**	**3**	**2.25**	**2**	**2.7**	**1.4**	**2**	**2**	**1.73**	**2**	**1.7**	**2**	**2**	**2**	**2**	**2.08**	**2.5**	**2**	**2**	**1**	**1.9**	**2.8**	**2.10**	**2.08**	**20.8**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	1	1	1	0.76	1	1	1	1	1	0.84	1	0.8	1	1	1	1	0.9	1	1	1	1	1	1	0.88	0.97	9.7
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0	1	1	1	0.66	1	0.8	0.7	1	1	0.89	1	0.9	0	1	0	1	0.96	0.6	1	1	1	0.8	1	0.94	0.81	8.1
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	1	1	1	1	1	0.9	0	1	0.7	0.57	1	0.7	1	1	1	1	0.62	1	1	1	1	0.8	0.8	0.68	0.87	8.7
Хэсгийн оноо				**3**	**2**	**3**	**3**	**3**	**2.42**	**3**	**2.7**	**1.7**	**3**	**2.7**	**2.30**	**3**	**2.4**	**2**	**3**	**2**	**3**	**2.48**	**2,6**	**3**	**3**	**3**	**2.6**	**2.8**	**2.50**	**2.65**	**26.5**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**7.2**	**8**	**7**	**9**	**8.16**	**8**	**9**	**5.6**	**8**	**8.3**	**7.66**	**9**	**7.2**	**7**	**9**	**8**	**9**	**7.63**	**8.1**	**9**	**9**	**7.5**	**7.2**	**9**	**7.76**	**7.99**	**79.9**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БАТЛАВ. БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ЁС
ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Л.ТӨГСБАЯР

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.02.24

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх түвшин үр дүн	Хариуцах гишүүн
Нэг. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх				
1	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн ажиллаж байгаа албан хаагчдын харилцан шинэ мэдлэг, арга зүйг түгээх, туршлага солилцох боломжийг бүрдүүлэх, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүйн боловсролыг Аймаг, нийслэлийн Боловсролын газрын болон яамны харьяа байгууллага дундын бүлэг үүсгэн Ёс зүйн дэд хорооны харилцан туршлага солилцох, боломжийг бүрдүүлэх, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт семинар, уулзалт зохион байгуулах	II, IY улиралд	Цахим бүлгийг үүсгэн байгуулж, арга хэмжээ зохион байгуулсан байна.	А.Цолмон С.Пүрэвсайхан Д.Одончимэг
2	Ёс зүйн талаарх эрх зүйн зохицуулалт бусад холбогдох мэдээллээр яамны албан хаагчид болон харьяа байгууллагын ёс зүйн дэд хороог мэдээллээр хангах	Улиралд 1 удаа	Холбогдох мэдээллээр тухай бүр хангасан байна.	Ч.Баярмаа Б.Мэнд-Амар
3	Яамны харьяа байгууллагуудаас ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлаар	I-IY улиралд	Судалгааг нэгтгэн дүгнэж арга хэмжээг тодорхойлсон байна.	А.Мөнх-Эрдэнэ Б.Мэнд-Амар

	судалгаа авч, хэрэгжүүлбэл зохих, тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, холбогдох арга хэмжээ авах			
4	Их дээд сургуульд суралцаж буй оюутан, ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад Монголын төрт ёсны түүхэн уламжлал, төрийн албанд ажиллахын давуу тал, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	I-IY улиралд	400-500 хүртэлх тооны оюутан сурагчдыг хамруулсан байна.	Д.Одончимэг А.Мөнх-Эрдэнэ
5	Яамны харьяа байгууллага, аймаг, нийслэлийн Боловсролын газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай танилцан арга зүйн дэмжлэг үзүүлэх	II, IY улиралд	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
6	Орон нутгийн ёс зүйн дэд хороотой хамтран багш, удирдах ажилтны ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	II-IY улиралд	400-500 хүртэлх тооны багш, удирдах ажилтан хамрагдсан байна.	А.Цолмон С.Пүрэвсайхан Б.Мэнд-Амар
7	Боловсролын яаманд шинээр томилогдсон албан хаагч, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн албан хаагч нарт зориулсан ёс зүйн талаарх мэдээлэл өгөх	III улиралд	Боловсролын яаманд шинээр томилогдсон албан хаагч, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн албан хаагч нарт зориулсан ёс зүйн талаарх мэдээлэл өгсөн байна	А.Мөнх-Эрдэнэ С.Пүрэвсайхан
Хоёр. Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, тайлагнах				
1	Холбогдох хууль тогтоомжоор харьяалуулсан гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган шийдвэрлэх	Тухай бүр	гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган шийдвэрлэсэн байна	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүний шийдвэрлэлт, хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээллийг цахим санд бүртгэх, хяналт тавих	Тухай бүр	Мэдээллийн цахим санг үнэн зөв хөтөлсөн байна.	Нарийн бичгийн дарга
Гурав. Дэд хорооны зохион байгуулалт үйл ажиллагааг тогтворжуулах:				
1	Засгийн газар, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөл болон төрийн байгууллага, бусад байгууллагаас Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжих, чадавхжуулах чиглэлээр зохион байгуулж буй танхимын болон цахим сургалтад Ёс зүйн дэд хороон дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг хамруулах	Тухай бүр	Танхимын болон цахим сургалтад хамрагдсан байна.	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
2	Боловсролын яамны цахим хуудасны “Ёс зүйн дэд хороо” цэсэнд дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ёс зүйн гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл болон үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээллийг тогтмол байршуулах	Тухай бүр	Үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр мэдээлсэн байна.	Нарийн бичгийн дарга
3	Ёс зүйн дэд хорооны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх, холбогдох баримт бичгийг яамны архивт хүлээлгэн өгөх	Хагас бүтэн жил	Тайланг хагас бүтэн жилээр тайлагнана.	Нарийн бичгийн дарга

---oOo---